



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 532

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цөмийн энергийн комиссын ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 27,500,000.00 (хорин долоон сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002379
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10-ны дугаар сарын 15-ны өдрийн
532... дугаар тогтоолын хавсралт



**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Соната-6, 00-73 УНБ, КМННУ41ВР8А432036	2008/2009	27,500,000.00	27,500,000.00	-	-	4,500,000.00
	Нийт үнэ		27,500,000.00 (хорин долоон сая таван зуун мянга)	27,500,000.00 (хорин долоон сая таван зуун мянга)	-	-	4,500,000.00 (дөрвөн сая таван зуун мянга)